



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн хэмжээнд үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна орчинд хөдөлгөөний ачаалал нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, иргэдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, зохицуулагч ажиллуулах талаар санал боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Саналыг 2016 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Ш.Бумаажав/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Т.ГАНТӨМӨР

УХА0501 9077367

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 08 сарын 16 өдрийн
А/407 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ш.Бумаажав	Нийслэлийн Авто замын газрын Тамгын хэлтсийн дарга
Ажлын хэсгийн гишүүд:	Б.Батболд	"Гудамж төсөл"-ийн дэд захирал
	Б.Батболд	Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын хөдөлгөөн зохицуулах гэрээт хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
	Д.Галбадрах	Нийслэлийн Тээврийн газрын Тээврийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Н.Гантулга	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга
	Т.Оюунбилэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Авто зам гүүрийн байгууламж хариуцсан ахлах мэргэжилтэн
	Д.Эрдэнэцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээний ахлах мэргэжилтэн
	Э.Сансар	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Б.Халиунаа	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Г.Ууганбаяр	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Цогзолмаа	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	В.Бэгз	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Д.Булган	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Р. Батцолмон	Нийслэлийн Авто замын газрын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Эдийн засагч
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Тээвэр хөдөлгөөн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн